

“Япон-Монголын Бизнес уулзалт” зохион байгуулах тухай мэдэгдэл

“Фронтнер Секьюритийз” компани нь 2017 оны 11-р сарын 24-ны өдөр Токио хотноо “Инвест Монголиа Токио” чуулга уулзалт зохион байгуулахтай холбогдуулан чуулга уулзалтын төлөөлөгч, Монголын хувийн хэвшлийн төлөөлөгчдөд зориулан 11-р сарын 24-ны хурал болох нэг өдөр Япон-Монгол “Бизнесийн мэдээлэл солилцох уулзалт”-ыг 3 дахь удаагаа зохион байгуулхаар болов.

Япон улсын парламентын гишүүд, төрийн холбогдох албан тушаалтнууд, хувийн хэвшил, бизнесийн төлөөлөгчид зэрэг 200 гаруй төлөөлөгчид Японы талаас оролцох болно. Эдгээр төлөөлөгчид дунд уул уурхай, банк санхүү, үл хөдлөх хөрөнгө, худалдаа арилжаа, хөдөө аж ахуй зэрэг салбарыг хамарсан хувийн хэвшлийн компаний төлөөлөл орж байгаа билээ.

Өнгөрсөн онд Монгол-Японы хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулагдаж, хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн нь хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Иймд Япон Улсын бизнесийн салбарынхантай уулзаж, өөрийн компани, бизнес санал, төслөө танилцуулах боломж олгох үүднээс энэхүү мэдээлэл солилцох бизнес уулзалтад өргөнөөр оролцохыг урьж байна.

◆Огноо : 2017 оны 11-р сарын 24 (Баасан гараг)-ны өдрийн 09:00-18:00 (08:30-аас бүртгэл эхэлнэ)

◆Болох газар: JICA Ichigaya Building, 10-5 Ichigaya Honmuracho, Shinjuku-ku (“Инвест Монголиа Токио” чуулга уулзалт болох газар)

◆Хөтөлбөр

Бизнесийн мэдээлэл солилцох уулзалт (Урьдчилан бүртгүүлсэн Монгол болон Японы компаниуд тусгай ширээн дээр сууж, өөрийн компанийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх танилцуулгыг хийнэ)

◆Бидний зүгээс уулзалтанд зориулж цөөн тооны орчуулагч ажиллах тул оролцогч компаниуд өөрсдөө орчуулагчаа бэлдэх буюу дарааллын дагуу орчуулагчаар үйлчлүүлэхийг урьдчилан мэдэгдэж байна.

◆Хураамж: Үзэсгэлэн гаргагч болон хурлын төлөөлөгчид үнэ төлбөргүй

◆Чөлөөт оролцогч зааланд чөлөөтэй явж, хүмүүстэй нэрийн хуудас солилцож, босоо уулзалт хийх боломжтой.

◆ Бизнес уулзалтад ширээ ашиглан компаниа сурталчилах: Ширээ түрээслэгч нь дараах линкээр <http://www.frontier-conference.com/tokyo/index.php/en/registere>, онлайн бүртгүүлэхээс гадна компанийхаа 100-150 үгэнд багтсан танилцуулга, цахим хуудас, салбарын нэр зэрэг мэдээлэлээ 11-р сарын 10-ны (Баасан гараг) дотор staff@frontier.mn хаягаар ирүүлнэ үү. Ширээний тоо хязгаартай байгаа тул түрүүлж бүртгүүлсэн дарааллаар сурталчилгаа хийх боломжтой болохыг анхаарна уу. Сурталчилгаа хийгч ширээн дээр тавих бага хэмжээтэй баннер авчирч болохоос гадна тараах материал, компанийн хэвлэмэл танилцуулгыг тодорхой тоо хэмжээгээр авчрах шаардлагатай.

◆Бүртгүүлэх эцсийн хугацаа: 2017 оны 11-р сарын 10 (Баасан гараг)

◆Холбоо барих Фронтнер Секьюритийз (Хариуцсан хүн: Нами)

Утас: +976 99707150

И-мэйл:staff@frontier.mn

